

МҮОНТ

Сонгуулийн сурталчилгаа явуулах 21 хоногийн хугацаанд МҮОНТ нь 13 нам эвсэл болон бие даагчдад нийтдээ 23 цаг зарцуулахаар төлөвлөжээ. Цагийг хуваарилахдаа 21 өдөрт хувааж нам тус бүр 3 удаагийн давтамжтайгаар 20 минутын нэвтрүүлэгт оролцохоор төлөвлөсөн байна. Энэ нь нийт 13 цагийг эзэлж байгаа юм. Үлдсэн 10 цагийг хуваарилахдаа Бие даагчдад дангаар нь 1 цаг 30 минутын эрх олгож үлдсэн 8 цаг 30 минутыг дахин 13 намдаа тэнцүү оролцоотойгоор хуваарилсан нь нэг намд дунджаар 40 орчим минутын цаг оногдож байгаа юм. Судалгааны явцад урьдчилан гаргасан хуваарийн дагуу тулгалт хийхэд төлөвлөсний дагуу ямар ч зөрөөгүй ажиллаж байв. Гэвч хуваарьт цагаас бусад цагт харилцан адилгүй байна.

1. Судалгааны хугацаанд МҮОНТ-ийн 106:05:50 цагийн бичлэгт мониторинг хийснээс 08:50:50 цаг нь сонгуулийн сурталчилгаатай холбогдсон мэдээлэл байна. Энэ нь нийт эфирийн цагийн 8%-ийг эзэлж байгаа юм.

МҮОНТ-ийн сонгуулийн сурталчилгааны хамгийн их цагийг МАН 34%-тайгаар эзэлжээ. Харин АН-д 14%-тай тэнцэх цаг оногдов. Ийнхүү буурсаар ХХН 7%, ИЗНН, 6%-ийг эзэлсэн бол ЭОНН, ИХН, ЭЧХН, Шударга ёс эвсэл, МСДН, ЭОН-ууд адил тэнцүү 5%-ийг эзэлж, Гурав дахь хүчин эвсэлд 4% оногдсон байна. Харин МНН, Бие даагчдад тус бүр адил 2% ногдуулжээ. Судалгааны хугацаанд МҮОНТ-ээр хамгийн бага мэдээлэгдсэн нам бол 1% эзэлсэн МУНН байв. Тэгэхээр сонгуульд оролцож буй бүх нам эвсэл бие даагчдын талаарх мэдээлэл их бага янз бүрийн хэмжээгээр сонгогчдод хүрсэн нь ажиглагдаж байна.

2. Сонгуулийн сурталчилгааны 08:50:50 цагийн нэвтрүүлгийн 01:56:42 цагийн нэвтрүүлэг нь аль нэг нам эвсэл, нэр дэвшигчийн тухай бус цэвэр сонгогчдын боловсролд зориулсан агуулгатай мэдээлэл байжээ. Энэ нь сонгуулийн тухай мэдээллийн 22%-ийг эзэлж байна. МҮОНТ бусад телевизүүдтэй харьцуулахад сонгогчдын боловсролд хамгийн их цаг зарцуулсан нь харагдаж байна.

3. МҮОНТ-ийн мэдээллийн чанарыг үнэлэхэд дийлэнх нь буюу 78% нь эерэг хандлагатай, 22% нь төвийг сахисан өнгө аястайгаар мэдээлжээ. Сөрөг аястай мэдээлэл ердөө 2 минут эзэлсэн нь нийт мэдээллийн 1%-д ч хүрэхгүй юм.

Эерэг өнгө аястай мэдээллийн тал шахам буюу 49% нь МАН-д, 31% нь АН-д, 9% нь Гурав дахь хүчин эвсэл-д, 8% нь ИЗНН-д оногдсон бол ИХН 2%, Бие даан нэр дэвшигчдэд ердөө 1%-ийн цагийг эзэлсэн байна. Харин энд дурьдагдаагүй бусад нам, эвсэл-ийн талаар эерэг өнгө аястай мэдээлэл нэвтрүүлээгүй байна.

4. Сонгуулийн сурталчилгаатай холбоотой нэвтрүүлгийн 48% нь оргил цагт, 52% нь энгийн цагт цацагдсан байна.

Оргил цагийн нэвтрүүлгийг субъектуудад хуваарилсан байдлыг авч үзвэл МАН хамгийн их цагийг эзэлсэн нь 20%-тай байв. Үүний араас 13%-иар ХХН орсон бол ИЗНН, ЭОНН адил 11%, АН, МСДН, ЭОН тус бүр ижил 10%-ийг эзэлж МНН, Шударга ёс эвсэл тэнцүү 3%, ИХН, Бие даагч, ЭЧХН, МУНН-ууд адил 2%-ийг эзэлж Гурав дахь хүчин эвсэлийн тухай мэдээлэл оргил цагийн нэвтрүүлгийн ердөө 1%-ийг эзэлсэн байна. Үүнээс үзэхэд МҮОНТ нь оргил цагаа бүх субъектуудад хуваарилсан боловч ижил тэнцүү биш гэдэг нь ажиглагдаж байна.

5. МҮОНТ-ийн сонгуулийн сурталчилгаатай холбоотой нэвтрүүлгийг хэлбэрийн хувьд ангилан үзвэл захиалгатай нэвтрүүлэг 05:17:12, сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг 01:56:42, далд сурталчилгааны шинжийг агуулсан мэдээлэл 01:36:56 цагийг эзэлсэн байна. Эдгээрийг хувиар илэрхийлвэл захиалгат нэвтрүүлэг 60%, сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг 22%, далд сурталчилгаа 18% байна.

6. МҮОНТ-ийн мэдээний хөтөлбөрт хийсэн шинжилгээгээр нийт 01:31:46 цагийн сонгуультай холбоотой мэдээлэл илэрсэн байна. Энэ нь нийт сонгуультай холбоотойгоор илэрсэн мэдээллийн 17%-ийг эзэлж байгаа юм.

Мэдээний хөтөлбөрт нам, эвсэл, бие даагчдын эзэлсэн хувь хэмжээг харьцуулан үзүүлвэл МАН-ын тухай мэдээлэл дангаараа 46%-ийг эзлэжээ. Харин АН 31%, Бие даагчид 8% Шударга ёс эвсэл 7%, ИЗНН 4%, МНН 3%-ийн цаг ногдсон бол ХХН-д 1%-ийн цаг оногджээ. Мэдээний хөтөлбөрөөр дээр

дурьдагдаагүй бусад нам эвслийн талаар дурьдах төдий өнгөрсөн боловч энэ нь 1%-д ч хүрээгүй байна.

7. Сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлгийг мэтгэлцээн болон бусад төрлийн сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг гэж ангилвал “Мэтгэлцээн” 47%, “Бусад төрөл” нь 53%-ийг эзэлжээ.

8. МҮОНТ-ээр далд сурталчилгааны шинжийг агуулсан мэдээлэл 01:36:56 байсны 47%-нь МАН-ын, 31% нь АН-ын, 8% нь Бие даагчдын, 6% нь Шударга ёс эвсэл, 4% нь ИЗНН-ын, 1% нь ХХН-ын мэдээлэл эзэлжээ.

25-р суваг телевиз

1. Сурталчилгалгааны хугацаанд МН25-р суваг телевизийн 96:09:10 цагийн бичлэгт мониторинг хийснээс 13:26:02 цаг нь буюу 14% нь сонгуулийн сурталчилгаатай холбогдсон мэдээлэл байлаа. Тус телевиз сонгуулийн сурталчилгаанд зориулсан нэвтрүүлгийнхээ 49%-ийг АН-д, 35%-ийг МАН-д, 10%-ийг ИЗНН, 3%-ийг ИХН-д, 2%-ийг Шударга ёс эвсэл-д, 1%-ийг Гурав дахь хүчин эвсэл-д оноосон бол МУНН, ЭОН, МСДН, ЭЧХН, ХХН намуудыг дурьдах төдий өнгөрч үлдсэн нам болон бие даагчдын талаар ямар ч мэдээлэл хүргээгүй байна.

2. Сонгуулийн сурталчилгаатай холбоотойгоор хүргэсэн 13:26:02 цагийн нэвтрүүлгийн 3 минут 56 секунд нь л хараат бус, сонгогчдын боловсролд зориулсан агуулгатай мэдээлэл байв. Энэ нь нийт мэдээллийн 1%-д ч хүрэхгүй байна.

3. 25-р суваг телевизээр цацагдсан сонгуулийн сурталчилгаатай холбогдсон нийт мэдээллийн 52% нь төлбөртэй, захиалгатай гэдэг нь илт танигдаж байв. Харин цаг үеийн мэдээний хөтөлбөрөөр гарсан сонгуулийн сурталчилгаатай холбоотой мэдээлэл нь нийт цагийн 10%-ийг эзлэв.

4. Мэдээллийн чанарын хувьд дийлэнх буюу 94% нь эерэг, 6% нь төвийг сахисан өнгө аястай мэдээлэл байв. Сөрөг аястай мэдээлэл 2 минут 46 секундыг эзэлсэн нь 1%-д хүрэхгүй байна. Эерэг өнгө аястай мэдээллийн талаас илүү буюу 62% нь АН-д, 20% нь МАН-д, 15% нь ИЗНН, 3% нь Гурав дахь хүчин эвсэл-д ногдсон бол бусад субъектуудын талаар эерэг аястай мэдээлэл цацаагүй байна.

5. Сонгуулийн сурталчилгаатай холбоотой нэвтрүүлгийн 65%-ийг оргил цагт, 35%-ийг энгийн цагт зарцуулжээ.

Оргил цагийн нэвтрүүлгийн 67%-ийг АН, 30%-ийг МАН, 2%-ийг ИЗНН, Шударга ёс эвсэл 1%-ийг-ийг тус тус эзэлж МУНН, ЭОН, МСДН, ЭЧХН, ИХН, ХХН-ийг дурьдах төдий мэдээлсэн бол ЭОНН, МНН, Гурав дахь хүчин эвсэл, Бие даан нэр дэвшигчдийн талаар оргил цагт огт мэдээлээгүй байна.

6. 25-р суваг телевизийн сонгуулийн сурталчилгаанд зориулсан нэвтрүүлгийг хэлбэрийн хувьд ангилан үзвэл төлбөртэй буюу төлбөртэй шинж агуулсан мэдээлэл 07:09:02, сонгогчдын боловсролд зориулсан мэдээлэл 0:04:24, далд сурталчилгааны шинжийг агуулсан мэдээлэл 6:12:36 цагийг эзэлжээ. Үүнийг хувиар илэрхийлвэл төлбөртэй сурталчилгаа 53%, далд сурталчилгаа 46%, сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг 1% байна.

Төлбөртэй нэвтрүүлэг цацсан цагийг судалгаанд хамрагдсан 6 өдөрт харьцуулан дунджаар илэрхийлвэл 1:11:30 секунд гарч байна. Энэ нь 25-р суваг телевизийн төлбөртэй нэвтрүүлгийн хугацаа хуулинд заасан 2 цагийг хэтрүүлээгүй мэт харагдаж байгаа боловч далд хэлбэрийн сурталчилгааны цагийг нь тооцон үзвэл өөр дүн гарч байна.

- Далд сурталчилгаа, төлбөртэй сурталчилгаа хоёрын цагийг нийлүүлэн 6 өдөрт хуваан дунджаар илэрхийлвэл 2:13:36 цаг нэг өдөрт ногдож байна.

7. Далд сурталчилгааны 35%-ийг АН эзэлсэн бол МАН 32%, ИЗНН 22%, ИХН 5%-ийг эзэлжээ. Харин Шударга ёс эвсэл, Гурав дахь хүчин эвсэл тус бүр 3%-ийн далд хэлбэрийн сурталчилгаа явуулсан байна.

8. 25-р суваг телевизийн мэдээний хөтөлбөрт шинжилгээ хийхэд 01:00:40 цагийн мэдээлэл нь сонгуультай холбоотой байв. Цаг үеийн шинжтэй мэдээний хөтөлбөрөөр намуудыг хэрхэн мэдээлсэн талаар шинжлэхэд 4 намын талаар л мэдээлсэн нь илрэв. Үүнд МАН 54%, Гурав дахь

хүчин эвсэл 20%, АН 15%, ИЗНН-д 11% тус тус оногдсон байна. Бусад нам эвслийн талаарх мэдээлэл мэдээний хөтөлбөрөөр цацагдаагүй байна.

TV9 телевиз

1. Сурталчилгааны хугацаанд “TV9” телевизийн 107:25:41 цагийн бичлэгт мониторинг хийснээс 16:14:25 цаг нь буюу 13% нь сонгуулийн сурталчилгаатай холбогдсон мэдээлэл байлаа. Тус телевиз сонгуулийн сурталчилгаанд зориулсан нэвтрүүлгийнхээ 50%-ийг АН-д, 24%-ийг Шударга ёс эвсэл-д, 23%-ийг МАН-д зориулж ИЗНН, ЭОН, МНН-д тус бүрт нь 1%-ийн цаг оноожээ. Бусад намд болон бие даагчдад оноосон цаг нь нийт мэдээллийн 1%-д ч хүрэхгүй байна.

2. Сонгуулийн сурталчилгаатай холбоотойгоор 16:14:25 цагийн нэвтрүүлэг цацсанаас 09 минут 40 секунд нь л хараат бус, сонгогчдын боловсролд зориулсан агуулгатай мэдээлэл байв. Энэ нь нийт мэдээллийн 1%-д л хүрч байгаа юм.

3. “TV9” телевизээр цацагдсан сонгуулийн сурталчилгаатай холбогдсон нийт мэдээллийн 73% нь төлбөртэй, захиалгатай гэж тэмдэглэгдсэнээс гадна төлбөртэй шинжийг агуулсан нэвтрүүлэг байв. Харин цаг үеийн мэдээний хөтөлбөрөөр гарсан сонгуулийн сурталчилгаатай холбоотой мэдээлэл нь нийт цагийн 13%-ийг эзлэв.

4. Мэдээллийн чанарын хувьд дийлэнх буюу 80% нь эерэг, 16% нь төвийг сахисан өнгө аястай мэдээлэл байв. Сөрөг өнгө аястай мэдээлэл 4%-ийг эзэлжээ. Эерэг өнгө аястай мэдээллийн цагийн тал шахам буюу 49% нь АН-д, 26% нь МАН-д, 21% нь Шударга ёс эвсэл-д, 2% нь ЭОН-д зарцуулагдсан бол ИЗНН, МНН-д адилхан 1% оногдсон байна. ЭОН 97 секунд эзэлсэн боловч энэ нь хувь эзлээгүй. Бусад нам, эвсэл, бие даагчдын талаар эерэг өнгө аястай мэдээлэл цацагдаагүй байна.

Сөрөг сурталчилгаанд нийт 0:42:24 цаг зарцуулсны 62%-нь дангаараа ЭОНН-ын тухай мэдээлэл байжээ. Түүнчлэн сөрөг мэдээллийн 36%-нь МАН-д, үлдсэн 2%-н ИЗНН-ын тухай мэдээлэл байв. Бусад нам, эвсэл болон бие даагчдын талаар сөрөг хандлагатай мэдээлэл илрээгүй байна.

5. Сонгуулийн сурталчилгаатай холбоотой нэвтрүүлгийн 50%-ийг оргил цагт, 50%-ийг энгийн цагт зарцуулжээ.

Оргил цагийн нэвтрүүлгийн 56%-ийг АН, 22%-ийг МАН, 17%-ийг Шударга ёс эвсэл, 3%-ийг-ЭОН эзэлсэн бол ИЗНН, Бие даагчдад адил тэнцүү 1% оногдсон байна. TV9 телевизийн ИЗНН, ЭОНН-ийг оргил цагаараа мэдээлсэн байдал нь нийт оргил цагийн 1%- ч хүрэхгүй байна. Дээр дурьдсанаас бусад нам, эвсэлийн талаар огт мэдээлэл цацагдаагүй байна.

6. “TV9” телевизийн сонгуулийн сурталчилгаанд зориулсан нэвтрүүлгийг хэлбэрийн хувьд ангилан үзвэл төлбөртэй буюу төлбөртэй шинж агуулсан мэдээлэл 11:54:54, сонгогчдын боловсролд зориулсан мэдээлэл 00:09:40, далд сурталчилгааны шинжийг агуулсан мэдээлэл 04:09:51 цагийг эзэлжээ. Эдгээрийг хувьчлан илэрхийлвэл төлбөртэй сурталчилгаа 73%, далд сурталчилгаа 26% эзэлж харин сонгогчдын боловсролд зориулсан мэдээлэл дөнгөж 1%-ийг эзэлж байгаа юм.

Энэ телевизийн төлбөртэй нэвтрүүлэг цацсан цагийг судалгаанд хамрагдсан 6 өдөрт харьцуулан дунджаар илэрхийлвэл 01:59:09 цаг гарч байна. Эндээс харахад TV9 телевизийн төлбөртэй сурталчилгаа хуулиар зөвшөөрөгдсөн 2 цагтаа дүйж байгаа гэж харагдаж байгаа боловч төлбөртэй гэдгээ илэрхийлээгүй далд хэлбэрээр цацсан мэдээллийн цагийг нэмж тооцвол өөр дүн гарсан.

Далд сурталчилгаа, төлбөртэй сурталчилгаа хоёрын цагийг нийлүүлэн 6 өдөрт хуваан дунджаар илэрхийлвэл 02:40:47 цаг нэг өдөрт ногдож байна.

7. TV9 телевизээр нийт 04:09:51 цагийн далд сурталчилгааны шинжийг агуулсан мэдээлэл цацсанаас 54% нь дангаараа Шударга ёс эвслийн тухай мэдээлэл байв. Харин АН 25%-ийг, МАН 19%-ийг эзэлж Бие даагчид болон ИЗНН, ЭОН-д тус бүр адилхан 1%-ийн цаг зарцуулжээ.

8. TV9 телевизийн цаг үеийн мэдээний хөтөлбөрт шинжилгээ хийхэд 02:05:12 цагийн мэдээлэл нь сонгуультай холбоотой байв. Цаг үеийн шинжтэй мэдээний хөтөлбөрөөр намуудыг хэрхэн мэдээлсэн талаар шинжлэхэд Шударга ёс эвсэл дангаараа 65%-ийг эзэлсэн байв. Түүний дараа МАН 21%, АН 9%, ИЗНН, ЭОН-ууд адил 1%-ийг эзэлжээ. Тус телевизээр Бие даагчдын талаар мэдээлсэн байдал нь 3%-д хүрч байна.

UBS телевиз

1. Сурталчилгааны хугацаанд “UBS” телевизийн 105:4:30 цагийн бичлэгт мониторинг хийснээс 08:55:20 цаг нь буюу 8% нь сонгуулийн сурталчилгаатай холбогдсон мэдээлэл байлаа. Тус телевиз энэ хугацаанд сонгуулийн сурталчилгаанд зориулсан нэвтрүүлгийнхээ 47%-ийг МАН-д, 29%-ийг АН-д, 12%-ийг Гурав дахь хүчин эвсэл-д, 5%-ийг ИЗНН-д, 4%-ийг Шударга ёс эвсэл-д, 3%-ийг ЭОН-д зориулжээ. Бусад намд болон Бие даагчдын талаар мэдээлээгүй байна.

2. Сонгуулийн сурталчилгаатай холбоотойгоор 08:55:20 цагийн нэвтрүүлэг цацсанаас сонгогчдын боловсролд зориулсан агуулгатай мэдээлэл огт байхгүй байна.

3. “UBS” телевизээр цацагдсан сонгуулийн сурталчилгаатай холбогдсон нийт мэдээллийн 35% нь төлбөртэй, захиалгатай гэж тэмдэглэгдсэнээс гадна төлбөртэй шинжийг агуулсан нэвтрүүлэг байв. Харин цаг үеийн мэдээний хөтөлбөрөөр гарсан сонгуулийн сурталчилгаатай холбоотой мэдээлэл нь нийт цагийн 9%-ийг эзлэв.

4. Мэдээллийн чанарын хувьд дийлэнх буюу 81% нь эерэг, 19% нь төвийг сахисан өнгө аястай мэдээлэл байв. Сөрөг өнгө аястай мэдээлэл 52 секунд цацагдсан нь 1%-д хүрэхгүй юм. Эерэг өнгө аястай мэдээллийн цагийн 50% нь МАН-д, 34% нь АН-д оногдсон бол Гурав дахь хүчин эвсэл, ИЗНН-ын мэдээлэл адил тэнцүү 6 хувийг эзэлж, ЭОН-д 4% нь зарцуулагдсан байна. Шударга ёс эвсэл-ийн талаар 2 минутын эерэг аястай мэдээлэл хүрсэн боловч энэ нь хувь эзлээгүй. Бусад нам, эвсэл, бие даагчдын талаар эерэг өнгө аясаар мэдээлээгүй байна.

5. Сонгуулийн сурталчилгаатай холбоотой нэвтрүүлгийн 78%-ийг оргил цагт, 22%-ийг энгийн цагт зарцуулжээ.

Оргил цагийн нэвтрүүлгийн 49%-ийг МАН, 35%-ийг АН, 4%-ийг ЭОН эзэлсэн бол Гурав дахь хүчин эвсэл, ИЗНН-д ижилхэн 6% оногджээ. Шударга ёс эвслийн талаар оргил цагт 1 минутын мэдээлэл хүргэсэн нь нийт мэдээллийн 1%-д ч хүрээгүй байна. Энд дурьдсанаас бусад нам болон Бие даагчдын талаар оргил цагт мэдээлэл цацаагүй байна.

6. “UBS” телевизийн сонгуулийн сурталчилгаанд зориулсан нэвтрүүлгийг хэлбэрийн хувьд ангилан үзвэл төлбөртэй буюу төлбөртэй шинж агуулсан мэдээлэл 07:55:42, далд сурталчилгааны шинжийг агуулсан мэдээлэл 00:59:38 цагийг эзэлжээ. Эдгээрийг хувьчлан илэрхийлвэл төлбөртэй сурталчилгаа 89%, далд сурталчилгаа 11% эзэлж байна. Харин сонгогчдын боловсролд зориулсан мэдээлэл цацаагүй байна.

Энэ телевизийн төлбөртэй нэвтрүүлэг цацсан цагийг судалгаанд хамрагдсан 6 өдөрт харьцуулан дунджаар илэрхийлвэл 01:19:17 цаг гарч байна.

Далд сурталчилгаа, төлбөртэй сурталчилгаа хоёрын цагийг нийлүүлэн 6 өдөрт хуваан дунджаар илэрхийлвэл 01:19:17 цаг нэг өдөрт ногдож байна. Эндээс харахад “UBS” телевизийн төлбөртэй сурталчилгаа хуулиар зөвшөөрөгдсөн 2 цагаасаа хэтрээгүй харагдаж байна

7. “UBS” телевизээр нийт 00:59:38 цагийн далд сурталчилгааны хэлбэртэй мэдээлэл цацсанаас 93% нь дангаараа МАН-ын тухай мэдээлэл байв. ИЗНН-д 4, АН-д 3% оногджээ. Харин бусад нам, эвсэл болон бие даагчдын талаар далд сурталчилгааны шинжтэй мэдээлэл цацагдаагүй байна.

Далд сурталчилгааг мэдээллийн агуулгаар нь А, Б, В гэж гурав ангилсан. Үүний дотор А ангиллыг мөн 1, 2 хэсэгт ангилан үзсэн. Тус телевизийн далд сурталчилгаа явуулсан цагийг агуулгаар нь ангилвал 99% нь А1, 1% нь Б хэлбэрийн далд сурталчилгаа байсан бол В хэлбэрийн далд сурталчилгаа 10 секунд илэрсэн нь хувь эзлээгүй байна. Харин А2 хэлбэрийн далд сурталчилгаа огт байгаагүй.

8. “UBS” телевизийн цаг үеийн мэдээний хөтөлбөрт шинжилгээ хийхэд 00:49:37 цагийн мэдээлэл нь сонгуультай холбоотой байв.

Цаг үеийн шинжтэй мэдээний хөтөлбөрөөр намуудыг хэрхэн мэдээлсэн талаар шинжлэхэд 96% нь МАН-ын тухай, үлдсэн 4% нь ИЗНН-ын мэдээлэл байв. Бие даагчид болон бусад нам эвслийн талаар мэдээлээгүй байна. Мэдээний хөтөлбөрөөр цацагдсан сонгуультай холбоотой мэдээллийн 68% нь төвийг сахисан байр сууринаас, 32% нь эерэг өнгө аястайгаар мэдээлжээ.

TV5 телевиз

1. Сурталчилгааны хугацаанд “TV5” телевизийн 110:54:40 цагийн бичлэгт мониторинг хийснээс 08:42:20 цаг нь буюу 10% нь сонгуулийн сурталчилгаатай холбогдсон мэдээлэл байлаа. Тус телевиз сонгуулийн сурталчилгаанд зориулсан нэвтрүүлгийнхээ 66%-ийг МАН-д, 22%-ийг АН-д, 6%-ийг ИЗНН, 3%-ийг Шударга ёс эвсэл-д, 2%-ийг ЭЧХ-д зориулжээ. МУНН, ЭОН, МСДН, ХХН-ын талаар тус бүр 17 секундын мэдээлэл хүргэсэн нь 1%-д ч хүрээгүй байна. Дурьдагдаагүй үлдсэн намуудын талаар огт мэдээлэл цацаагүй байна. Харин бие даагчдад 1% оногджээ.

2. Сонгуулийн сурталчилгаатай холбоотойгоор хүргэсэн 08:42:20 цагийн нэвтрүүлгийн 80 секунд нь л хараат бус, сонгогчдын боловсролд зориулсан агуулгатай мэдээлэл байв. Энэ нь нийт мэдээллийн 1%-д ч хүрэхгүй байна.

3. “TV5” телевизээр цацагдсан сонгуулийн сурталчилгаатай холбогдсон нийт мэдээллийн 48% нь төлбөртэй, захиалгатай гэдэг нь илт танигдаж байв. Харин цаг үеийн мэдээний хөтөлбөрөөр гарсан сонгуулийн сурталчилгаатай холбоотой мэдээлэл нь нийт цагийн 15%-ийг эзлэв.

4. Мэдээллийн чанарын хувьд 50% нь төвийг сахисан өнгө аястай, 49% нь эерэг өнгө аястай, 1% нь сөрөг мэдээлэл байв. Эерэг өнгө аястай мэдээллийн талаас илүү буюу 89% нь МАН-д, 6% нь ИЗНН-д, 5% нь АН-д тус тус оногджээ. Бусад нам, эвсэл болон субъектуудын талаар эерэг аястай мэдээлэл цацаагүй байна. TV5 телевиз МАН-ыг хамгийн их төвийг сахисан байдлаар мэдээлжээ. Энэ нь 84%-ийг эзэлж байна. Харин Шударга ёс эвсэл-д 7%, АН-д 6%, МУНН-д 1% тус тус ногджээ. Бусад нам, эвсэл, бие даагчдын талаар төвийг сахисан байдлаар мэдээлэл 1%-д ч хүрэхгүй байна. TV5 телевиз нийт 3 минут 46 секундын сөрөг аястай мэдээлэл явуулсан нь бүхэлдээ Шударга ёс эвслийн тухай мэдээ байв.

5. Сонгуулийн сурталчилгаатай холбоотой нэвтрүүлгийн 78%-ийг оргил цагт, 22%-ийг энгийн цагт зарцуулжээ.

Оргил цагийн нэвтрүүлгийн 87%-ийг МАН, 7%-ийг АН, 4%-ийг Шударга ёс эвсэл 2%-ийг-ИЗНН тус тус эзэлж, бие даагчид болон бусад нам эвслийн талаар оргил цагт мэдээлэл цацаагүй байна.

6. “TV5” телевизийн сонгуулийн сурталчилгаанд зориулсан нэвтрүүлгийг хэлбэрийн хувьд ангилан үзвэл төлбөртэй буюу төлбөртэй шинж агуулсан мэдээлэл 06:45:10, далд сурталчилгааны шинжийг агуулсан мэдээлэл 01:54:30 цагийг эзэлжээ. Үүнийг хувиар илэрхийлвэл төлбөртэй сурталчилгаа 78%, далд сурталчилгаа 22% байна. Сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг дөнгөж 80 секунд эзэлжээ.

- Тус телевизийн төлбөртэй нэвтрүүлэг цацсан цагийг судалгаанд хамрагдсан 6 өдөрт харьцуулан дунджаар илэрхийлвэл 01:07:31 секунд гарч байна. Энэ нь TV5 телевизийн төлбөртэй нэвтрүүлгийн хугацаа хуулинд заасан 2 цагийг хэтрүүлээгүй нь харагдаж байна.

- Далд сурталчилгаа, төлбөртэй сурталчилгаа хоёрын цагийг нийлүүлэн 6 өдөрт хуваан дунджаар илэрхийлвэл 01:26:36 цаг нэг өдөрт ногдож байна.

7. Далд сурталчилгааны 51%-нь МАН-д, 34% нь Шударга ёс эвсэлд, ЭЧХН, МСДН, ХХН, ЭОН, МУНН намуудад адил тэнцүү 3% оногджээ.

- Далд сурталчилгааг мэдээллийн агуулгаар нь А, Б, В гэж гурав ангилсан. Үүний дотор А ангиллыг мөн 1, 2 хэсэгт ангилан үзсэн. Тус телевизийн далд сурталчилгаа явуулсан цагийг агуулгаар нь ангилвал 8% нь А1, 35% нь А2, 30% нь Б хэлбэрт, 27% нь В хэлбэрт хамаарагдаж байна.

8. “TV5” телевизийн мэдээний хөтөлбөрт шинжилгээ хийхэд 01:20:09 цагийн мэдээлэл нь сонгуультай холбоотой байв.

Цаг үеийн шинжтэй мэдээний хөтөлбөрөөр намуудыг хэрхэн мэдээлсэн талаар шинжлэхэд МАН 31%, ИЗНН 19%, Шударга ёс эвсэл 16%, ЭЧХН 15% АН 9%, ЭОНН, МУНН, ИХН, ЭОН, МСДН, ХХН, -уудын эзэлсэн цаг нийлээд 1%-ийг эзэлжээ. TV5 телевиз мэдээний хөтөлбөрөөрөө бие даагчдыг мэдээлсэн байдал нь 7%-тай байна. Харин Гурав дахь хүчин эвсэл, МНН-уудын талаар мэдээний хөтөлбөрт ороогүй байна.